



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/32

Амардалай

Г Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан  
оготнотой микробиологийн аргаар  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01 ний өдрийн 185 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 15 ний өдрийн A/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2024 оны 04 сарын 15-25 ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал ( Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Баттотох ( Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

Б.Баатарсүрэн ( 3-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам( 2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий ( 1-р багийн Засаг дарга)


Д.Цэнд-Аюуш ( Газрын албаны мэргэжилтэн)

Б.Баярмаа ( ЗДТГ-ын нярав)

2. Тус ажлыг зохион байгуулахад гарах унаа, шатахуун, хөдөлмөр хамгааллын зардлыг сумын байгаль хамгаалах сан, мал хамгаалах сангийн санхүүжилтээр шийдвэрлэж, холбогдох баримтыг бүрдүүлж ажиллахыг сангуд хариуцсан нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Малчид, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Тайлан мэдээний хэрэгжилтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хугацаанд хүргүүлэхийг ажлын хэсгийнхэнд үүрэг болгосугай.



433401063